



**УЛААНБААТАР ХОТЫН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 3-Р ХОРООНЫ НУТАГ ДЭВСГЭРТ
БАЙРЛАХ “ХИМИЙН БОДИС ИМПОРТЛОХ, ХУДАЛДАХ, ХИМИЙН БОДИСЫН
АГУУЛАХ” ТӨСЛИЙН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

ХЯНАСАН:

БОАЖЯ-ны ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН БАЙГАЛИЙН
НӨӨЦИЙН УДИРЛАГЫН ГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭН

... П. ШИНЭЦЭЦЭГ

ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАСАН:

“ПИ ЭС СИ” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

.....Ч.ЭРДЭНЭЦЭЦЭГ

“ПИ ЭС СИ” ХХК-ийн

Байгаль орчны менежмент хариуцсан менежер

..... Б. ПҮРЭВЖАВ

Улаанбаатар 2022 он

2022 он

ГАРЧИГ

ОРШИЛ.....	2
1. Төслийн товч танилцуулга.....	3
1.1 Төслийн ерөнхий мэдээлэл.....	3
1.2 Төслийн хүчин чадал, техник технологи.....	4
1.3 Төслийн нийгэм, эдийн засгийн үр өгөөж.....	13
2. Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл, түүний эрсдэлээс сэргийлэх шаардлагууд.....	14
2.1 Импортлох, худалдах, ашиглахад тавигдах нийтлэг шаардлага.....	14
2.2 Хадгалахад тавигдах үндсэн шаардлага.....	14
2.3 Тээвэрлэхэд тавигдах үндсэн шаардлага.....	15
2.4 Устгахад тавигдах үндсэн шаардлага.....	15
3. Төслийн эрсдэлийн үнэлгээ, менежмент.....	16
4. Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт	19
4.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....	16-18
4.2 Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	22
4.3 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	23
4.4 БО-ний менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ.....	24
4.5. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	26
Дүгнэлт	27

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1	Төслийн байршлын зураг.....	3
Зураг 2	Бараа бүтээгдэхүүн борлуулж буй дэлгүүр.....	4
Зураг 3	Химийн бодисын агуулах зураг.....	13

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1	Тусгай зөвшөөрлөөр нэвтрүүлдэг HILTI фирмийн бодисын жагсаалт	5
Хүснэгт 2	Тусгай зөвшөөрлөөр нэвтрүүлдэг тест газнуудын жагсаалт.....	10-11
Хүснэгт 3	Тусгай зөвшөөрлөөр нэвтрүүлдэг бусад бодисын жагсаалт	11-12
Хүснэгт 4	Хор уршгийн үнэлгээний шалгуур.....	16
Хүснэгт 5	Магадлалын үнэлгээний шалгуур.....	17
Хүснэгт 6	Эрсдэлийн үнэлгээний матриц.....	17
Хүснэгт 7	Эрсдэлийн түвшин.....	17

ОРШИЛ

“Пи Эс Си” ХХК нь “Химийн бодис импортлох, худалдаалах, химийн бодисын агуулах ” төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллийг тодорхойлох, түүнийг бууруулах, арилгах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардлыг төлөвлөх мөн химийн бодис агуулах явцад мөрдөж ажиллах байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр боловсруулах зайлшгүй шаардлагатай болсон юм.

Уг ажлыг гүйцэтгэхдээ Байгаль орчныг хамгаалах, Байгаль орчинд нөлөөлөх байдлын тухай болон, химийн хорт болон аюултай бодистой холбогдох хуулиуд, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А-05 дугаар тушаалаар баталсан Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын тухайн жилд хэрэгжүүлэх “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн Сайд, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2009 оны 2 дугаар сарын 03-ны өдрийн 28/40/29 дүгээр хамтарсан тушаалаар баталсан “Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам” зэргийг болон 2017 оны байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ, 2019 онд хийгдсэн тодотголыг үндэслэн боловсруулав.

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн ерөнхий мэдээлэл

Төслийн нэр. “Химийн бодис импортлох, ашиглах, худалдаалах”

Төслийн ангилал. Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тухай хуулийн дагуу уг төсөл нь үйлчилгээний төслийн ангилалд хамаарна.


Төсөл хэрэгжүүлэгч. “Пи Эс Си” ХХК

Улсын бүртгэлийн дугаар: 9019021042

Регистрийн дугаар: 2822733

Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг. Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Үйлдвэрийн гудамж, 68/1 тоот Утас: 7575-4584

Төслийн байршил. Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт, Нийслэлийн засаг даргын 2018 оны А/839 тоот шийдвэр, газар ашиглах эрхийн 000346130 тоот гэрчилгээгээр олгогдсон 1105 м² талбай. Төслийн байршлыг доорх зурагт харуулав.




Зураг 1. Төслийн байршлын зураг

Төслийн зорилго. Швейцарын “Hilti”, “Leica”; ХБНГУ-н “Draeger”, “Testo”, “Elora” зэрэг фирмүүдийн барилга, уул уурхайн зориулалттай багаж болон хувь хүний хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны багаж, тоноглол хэрэгслүүд ба бусад барилгын холбогдолтой бүхий л бүтээгдэхүүнүүдийг импортолж, худалдан борлуулах.

1.2. Төслийн хүчин чадал, техник технологи

Хүчин чадал. Төсөл нь одоогийн байдлаар 21 ажилтантай өөрийн эзэмшлийн 2 давхар үйлчилгээний байртай бөгөөд нэг давхарт нь хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах болон бусад барилга байгууламжтай холбоотой бараа материал борлуулах дэлгүүр ажиллуулж байна.



Зураг 2. Бараа бүтээгдэхүүн борлуулж буй дэлгүүр

ХБНГУ-ын 100%-ийн хөрөнгө оруулалттай “Пи Эс Си” ХХК нь 2004 оны 4-сарын 8-нд байгуулагдан үйл ажиллагаагаа эхэлсэн ба Швейцарын “Hilti”, “Leica”; ХБНГУ-н “Draeger”, “Testo”, “Eloga” зэрэг фирмүүдийн барилга, уул уурхайн зориулалттай багаж болон хувь хүний хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны багаж, тоноглол хэрэгслүүд ба бусад барилгын холбогдолтой бүхий л бүтээгдэхүүнүүдийг импортолж, худалан борлуулах үйл ажиллагааг явуулж байна. Төсөл хэрэгжүүлэгч нь цухас дурдахад дараах нэр төрлийн бараа бүтээгдэхүүнийг импортолж хэрэглэгчдэд нийлүүлж байна. Үүнд:

HILTI

Hilti брэнд нь гар болон цахилгаан багаж оруулж ирэхээс гадна химийн сайн чанарын бэхэлгээний шингэн тэлэгчүүд буюу бетонд арматур төмөр анкерлагч шаваас, чигжээс, силикон зэргийг дараах нэр төрлөөр оруулж ирдэг: HIT-RE 500, HIT HY-200, галаас тусгаарлах бүтээгдэхүүнүүд, барилгын химийн материал гэх мэт бүтээгдэхүүнийг нийлүүлдэг.

Эдгээр шаваас, чигжээс, галаас тусгаарлах бүтээгдэхүүнүүд нь 2020 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн А/60, А/12 дугаар тушаалын 2.1.4 ба 2.1.4.2.-т заасны дагуу Барилгын материалын норматив, стандарт шаардлага хангасан гэрчилгээтэй, үйлдвэрлэгчийн савлагаатай барилгын будаг, лак, цавуу, эмульс, чигжээс, шаваас нь тусгай зөвшөөрөл шаардахгүйгээр импортлох болсон.

DRAEGER



Test gas: DRAEGER -т хувь хүний ажлын аюулгүй орчин, хөдөлмөр хамгаалалд зориулагдсан аливаа хорт хий, агаарын болон хүчилтөрөгчийн дутмаг орчныг урьдчилан мэдрэгч, илрүүлэгч олон төрлийн багажууд байдаг. Түүнээс гадна замын цагдаагийнханд өргөнөөр хэрэглэгддэг хүний цусан дахь согтуурлын хэмжээг маш богино хугацаанд илрүүлэгч Alcotest мөн дээрх багажийн тоонд багтдаг. Эдгээр багажуудад 6 сараас 1 жил тутамд тохиргоо хийгдэх зайлшгүй шаардлагатай байдаг ба үүнд нэн хэрэгцээтэй тест хийнүүдийг бид импортолдог.

Тест газ болон багажийг зориулалтын холбогчоор хооронд нь холбон ашиглах зааврын дагуу тохиргоог хийж шалгана.

Draegersorb: BG4 хэмээх амьсгалын аппарат нь хүчилтөрөгчийн дутмаг орчинд ажилладаг хүмүүст зориулагдсан ба Draegersorb гэгч бодис нь энэхүү амьсгалын аппаратын амьсгалаас гарах нүүрсхүчлийн хийг шингээн авч цэвэр агаараар амьсгалах боломжийг хангах зориулалттай бүтээгдсэн юм.

Дээр дурдсан багажуудын зөв ажиллагааг хянах болон тохируулах зориулалттай (Calibration gas) тест газууд, BG4 амьсгалын аппаратын амьсгалаас гарах нүүрсхүчлийн хийг шингээн авч цэвэр агаараар амьсгалах боломжийг хангах зориулалттай Draegersorb бодис мөн бусад цэвэрлэгээний болон ариутгалын бодисуудыг хэрэглэгчийн захиалгаар Монгол улсад импортлон худалдаалж байна.

Хүснэгт 1. Тусгай зөвшөөрлөөр нэвтрүүлдэг тест газнуудын жагсаалт

№	Монгол нэр	Англи нэр	Найрлага / Томьёо	Олон улсын дугаар (CAS number)
Алкохол тестер болон хорт хий илрүүлэгч багажуудад тохиргоо хийх зориулалт бүхий Тест газнууд				
1	Устөрөгч /агаар	Hydrogen	H2/Air	1333-74-0
2	Хүхэрт устөрөгч/ азот	Hydrogen Sulphide in nitrogen	H2S/N2	7783-06-4
3	Азот	Nitrogen	N2	7727-37-9
4	Азотын оксид/ азот	Nitrogen Monoxide in nitrogen	NO /N2	10102-43-9
5	Азотын 2ч исэл /азот	Nitrogen Dioxide in nitrogen	NO2 /N2	10102-44-0
6	Азотын 2ч исэл /агаар	Nitrogen Dioxide in air	NO2 /air	10102-44-0
7	Аммиак /азот	Ammonia in nitrogen	NH3 /N2	7664-41-7
8	Хүхрийн давхар исэл /азот	Sulfur Dioxide in nitrogen	SO2 /N2	7446-09-5
9	Хүхрийн давхар исэл /агаар	Sulfur Dioxide in air	SO2 /air	7446-09-5
10	Нүүрсхүчлийн хий /азот	Carbon Dioxide in nitrogen	CO2 /N2	124-38-9
11	Нүүрсхүчлийн хий /агаар	Carbon Dioxide in air	CO2 /air	124-38-9
12	Нүүрстөрөгчийн дутуу исэл /азот	Carbon Monoxide in nitrogen	CO /N2	630-08-0
13	Нүүрстөрөгчийн дутуу исэл /агаар	Carbon Monoxide in air	CO /air	630-08-0
14	Хүчилтөрөгч /азот	Oxygen in nitrogen	O2 /N2	7782-44-7
15	Бутадиен /агаар	1,3-Butadiene in air	C4H6 /air	106-99-0
16	Изобутан /агаар	Isobutylene in air	C4H8 /air	115-11-7
17	Метан	Methane	CH4	74-82-8

18	Метан /азот	Methane	CH ₄ /N ₂	74-82-8
19	Метан /агаар	Methane	CH ₄ /air	74-82-8
20	Согтолтын тун илрүүлэгч багажийн үйл ажиллагаа хянагч /азот	Gas mixture in nitrogen	C ₂ H ₅ OH /N ₂	64-17-5
21	Хлор /азот	Chlorine in nitrogen	Cl ₂ /N ₂	7782-50-5
22	Цианид илрүүлэгч багажийн үйл ажиллагаа хянагч /азот	Cyanide in nitrogen	HCN /N ₂	74-90-8
23	Хлорт устөрөгч /азот	Hydrogen chloride in nitrogen	HCl /N ₂	7647-01-0
24	Фосфин /азот	Phosphine in nitrogen	PH ₃ /N ₂	7803-51-2
25	Холимог хий /азот	Gas mixture in nitrogen	CH ₄ , H ₂ S, CO, CO ₂ , O ₂ /N ₂	7783-06-4 630-08-0 124-38-9 74-82-8 7782-44-7 7727-37-9
26	Холимог хий /азот	Gas mixture in nitrogen	CO, CO ₂ , O ₂ /N ₂	630-08-0 124-38-9 7782-44-7
* Жич: (1-26) Эдгээр хийнүүд дангаар болон хийн холимгоор захиалагчийн хүсэлтийн дагуу импортлогдоно.				

Хүснэгт 2. Тусгай зөвшөөрлөөр нэвтрүүлдэг бусад бодисын жагсаалт

Нүүрсхүчлийн хий шингээгч болон бусад цэвэрлэгээний, ариутгалын бодисууд				
27	Натригтай шохой (Нүүрсхүчлийн хий шингээгч)	Draegersorb, Soda Lime (CO ₂ Absorber)	Calcium hydroxide	1305-62-0
			Sodium hydroxide	1310-73-2
			Water	7732-18-5

Төсөл хэрэгжүүлэгч “Пи Эс Си” ХХК нь энэхүү химийн хийнүүдийг хэрэглэгчдийн захиалсан хэмжээгээр нь импортлон нийлүүлэх бөгөөд эдгээр бодисуудын жилд импортлох хэмжээ нь хэрэглэгчийн эрэлт, хэрэгцээнээс хамааран янз бүр юм.

Химийн бодис хадгалах агуулах.

“Пи Эс Си” ХХК нь импортоор оруулж ирсэн химийн бодисуудыг Хан-Уул дүүргийн 3-р хороонд байрлах өөрийн компанийн агуулахад хадгалдаг.



Зураг 3. Химийн бодисын агуулах

Ажилчдын хөдөлмөр хамгаалал. “Пи Эс Си” ХХК нь бараа бүтээгдэхүүний ачилт, буулгалт, тээвэрлэлтийн үеийн ажилчдад хөдөлмөр аюулгүй байдлын хувцсаар хангаж хөдөлмөрийн дотоод журмыг ажилчид мөрдөж байгаа эсэхэд байнга хяналт тавьж ажиллаж байна. Бид ажилчдын эрүүл хооллолт, хөдөлмөрийн аюулгүй байдалд зориулсан төсөв баталдаг бөгөөд үүнд байнга анхаарал тавин ажилладаг.

1.3. Төслийн нийгэм, эдийн засгийн үр өгөөж

“Пи Эс Си” ХХК-ийн дээрх төсөл хэрэгжсэнээр 21 хүнд ажлын байр бий болж барилга, уул уурхайн салбарт ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдал хангагдаж улмаар тухайн төслийн тогтвортой үйл ажиллагаа явуулах таатай нөхцөл бүрдэхээс гадна улсын төсөвт тодорхой хэмжээний татвар төлөгдөж, орон нутгийн ядуурлыг бууруулахад дэмжлэг болно.

2. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ, ТҮҮНИЙ ЭРСДЭЛЭЭС СЭРГИЙЛЭХ ШААРДЛАГУУД

Төсөл нь химийн хорт болон аюултай бодисыг импортлох, хадгалах, худалдах, тээвэрлэх, устгах явцад хүний эрүүл мэнд, байгаль орчин, мал, амьтанд учруулах сөрөг нөлөөлөл болон эрсдэлээс урьдчилан сэргийлэх, учирсан хор уршгийг арилгах арга хэмжээг өөрийн зардлаар авч хэрэгжүүлнэ. Химийн хорт болон аюултай бодистой харьцах ажиллагсдыг сургалтад (бодис бүрийн хор аюулын лавлах мэдээлэл, аюулгүй ажиллагааны зааварчилгаа, болзошгүй ослын үед авах арга хэмжээ г.м) хамруулж, гарын үсэг зуруулсны дараа ажиллуулах ба сургалтад хамрагдаагүй тохиолдолд химийн бодистой ажиллахыг хориглоно.

Болзошгүй аюул, ослын үед ашиглах зориулалтын бүрэн ажиллагаатай гал унтраах багаж хэрэгсэл, хор саармагжуулах бодис, уусмалыг ажлын байранд байрлуулах ба химийн бодистой харьцах ажиллагсад арьс, нүд болон амьсгал хамгаалах зориулалтын, стандартын шаардлага хангасан хүн нэг бүрийн хамгаалалтын хэрэгслээр хангагдсан байх ёстой.

2.1. Импортлох, худалдах, ашиглахад тавигдах нийтлэг шаардлага

Химийн хорт болон аюултай бодис импортлох, худалдах, ашиглахад эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авсан байх шаардлагатай бөгөөд зөвшөөрөл авахдаа дараахь мэдээлэл бүхий материалуудыг бүрдүүлнэ:

- Бодисын нэр, томъёо;
- Худалдааны болон техникийн нэр;
- Олон улсын бүртгэлийн дугаар;
- Импортлох тоо хэмжээ;
- Хор аюулын лавлах мэдээлэл;
- Үйл ажиллагаа явуулах ажлын байрын дүгнэлт;
- Тухайн бодис, түүний хольц, хаягдлыг устгах аргачлал, тээвэрлэх арга г.м.

2.2. Хадгалахад тавигдах үндсэн шаардлага

- Химийн хорт болон аюултай бодисыг түүний онцлог шинж чанарыг нь харгалзан зориулалтын тусгай агуулахад хадгалах;
- Химийн хорт болон аюултай бодисыг тухайн бодисын хор аюулын лавлах мэдээлэлд заасан зааврын дагуу хадгалах;
- Хадгалж байгаа химийн хорт болон аюултай бодисын сав, баглаа боодол нь тухайн бодисын нэр, анхааруулах тэмдэг, аюулын шинж чанарыг тод, томруун бичсэн хаяг шошготой байх;

2.3. Тээвэрлэхэд тавигдах үндсэн шаардлага

- Химийн хорт болон аюултай бодисыг техникийн болон аюулгүйн шаардлага хангасан тээврийн хэрэгслээр тээвэрлэх бөгөөд уг тээврийн хэрэгсэлд анхааруулах тэмдэг, аюулын шинж чанарын тухай санамж байрлуулах;
- Химийн хорт болон аюултай бодисыг тухайн бодисын хор аюулын лавлах мэдээлэлд заасан зааврын дагуу тээвэрлэх;
- Тээвэрлэлтийн үед ачаа унах, сав баглаа боодол цоорох, эвдэрч гэмтэх, холилдохоос урьдчилан сэргийлж, хөдөлгөөнгүй сайтар бэхэлж ачих;
- Химийн хорт болон аюултай ачаа тээвэрлэх тээврийн хэрэгслийн хурд 25-30 км/цагаас хэтрэхгүй, 2 тээврийн хэрэгслийн хоорондын зай 50 метрээс багагүй байх;
- Химийн хорт болон аюултай бодисын хайрцаг сав нь гэмтэлтэй, тээврийн хэрэгсэл бүрэн бус, бичиг баримт зөрчилтэй, анхааруулга, тэмдэг тэмдэглээгүй нөхцөлд тээвэрлэлт хийхгүй байх;
- Химийн хорт болон аюултай бодисыг тээвэрлэх тээврийн хэрэгслийн жолооч болон түүнийг дагалдан явах ажилтанд химийн бодис бүрийн хор аюулын лавлах мэдээлэл, аюулгүй ажиллагааны зааварчилгаа зэргийг танилцуулж, гарын үсэг зуруулсан байх;
- Тээвэрлэлтийн явцад болзошгүй аюул учирсан тохиолдолд үүссэн хор уршгийг арилгах зориулалтын багаж хэрэгсэл, саармагжуулах бодис, уусмалыг тээврийн хэрэгсэлд бэлэн байлгах;

2.4. Устгахад тавигдах үндсэн шаардлага

- Химийн бодисын хаягдал устгах цэг, талбайн байршлыг тухайн орон нутгийн хөгжлийн хэтийн төлөв, төв суурин газрын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан нутаг дэвсгэрийн байгаль орчны суурь нөхцөл байдлыг үндэслэн тогтоох ба байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэсэн байх;
- Ус сувгийн хоолой, зоорь хонгил гэх мэт их хэмжээний даралтат сав аюултай байх магадлалтай орчинд хаяхгүй байх;
- Химийн хорт болон аюултай бодисыг тухайн бодисын хор аюулын лавлах мэдээлэлд заасан зааврын дагуу хадгалах;

3. ТӨСЛИЙН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ, МЕНЕЖМЕНТ

Төслийн химийн бодисын эрсдэлийн үнэлгээний гол зорилго нь төслийн худалдаалж буй химийн бодисуудаас байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллийг тодорхойлох, түүнийг бууруулах, арилгах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардлыг төлөвлөх, мөн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр боловсруулах зэрэг юм.

“Химийн хорт болон аюултай бодисын тухай” хуулиар онцгой хортой, аюултай бодисыг тээвэрлэх, импортлох, хадгалах, худалдах, хэрэглэх, хэрэглээний шаардлага хангахгүй болсон үлдэгдэл хаягдлыг устгах үйл ажиллагааг Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тусгай зөвшөөрөлтэйгөөр зохицуулахаар хуульчилсан байдаг. Байгаль орчин аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайд, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2009 оны 02 сарын 03-ний өдрийн 28/40/29 дүгээр хамтарсан тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Химийн хорт ба аюултай бодисын эрсдэлийн үнэлгээ хийх журам”-ын дагуу тухайн бодис болгоны физик химийн шинж чанар, хор аюулын ангилал, учруулах аюул, хордлогын шинж тэмдэг, түүнээс урьдчилан сэргийлэх, аюулыг арилгах арга хэмжээ, бодисыг тээвэрлэх, хадгалах, саармагжуулах, ашиглах, хамгаалах хэрэгсэл, анхны тусламж үзүүлэх, байгаль орчинд нөлөөлөх байдлын талаар доорх байдлаар авч үзэв. Мөн агуулахын хэмжээнд үүсэж болзошгүй эрсдэлийг нэгтгэж дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 3. Хор уршгийн үнэлгээний шалгуур

Зэрэг-лэл	Уршиг	Эрсдэлд өртөгч ба эрсдэлийн тодорхойлолт		Уршгийг бууруулах, арилгах шийдэл
		Хүн ам	Эд хөрөнгө	
I	Ялим-гүй	Химийн бодист хордохгүй	Хохиролд өртөхгүй	Тусгай хамгаалах төхөөрөмж болон хамгаалалтын хувцас шаардлагагүй
II	Бага	Химийн бодист хордсон нөхцөлд анхны тусламжаар эдгэрнэ	Бага зэрэг хохиролд өртөнө	Эрсдэл үүссэн нөхцөлд анхны тусламжаар шийдэх шаардлагатай
III	Дунд	Химийн бодист хордсон нөхцөлд эмнэлгийн тусламж шаардлагатай	Дунд зэрэг хохиролд	Анхны тусламж болон эмнэлгийн тусламж авах
IV	Их	Химийн бодист хордох, түлэгдэх зэргээс болж хөдөлмөрийн чадвараа алдах	Төсөл хэрэгжүүлэгч эд хөрөнгө болон мөнгөөрөө хохирно	Анхны тусламж, эмнэлэг, онцгой байдал болон бусад байгууллагуудын тусламж авах
V	Маш их	Химийн бодист хордож амь насаа алдах	Төсөл хэрэгжүүлэгч маш их хэмжээний хохирол амсах	Анхны тусламж, эмнэлэг, онцгой байдал болон бусад байгууллагуудын тусламж авах

Хүснэгт 4. Магадлалын үнэлгээний шалгуур

Зэрэглэл	Магадлал	Эзлэх хувь	Эрсдэлийн тодорхойлолт
I	Бараг болохгүй	<5	Гаднын ямар нэгэн нөлөөгөөр эрсдэл үүсэж магадгүй.
II	Магад болохгүй	5-20	Химийн бодисыг ачиж, буулгах үед ажилчдын хариуцлагагүй байдал, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаагүйгээс үүсэж болзошгүй эрсдэл.
III	Болзошгүй	20-50	Химийн бодисын тээвэрлэлт, хадгалалт, ачиж буулгах үед химийн бодистой харьцах дүрэм, журмыг баримталгаагүйн улмаас үүсэж болзошгүй эрсдэл.
IV	Магад болох	50-70	Агуулахын бараг бүх шат дамжлагад эрсдэлтэй байж болзошгүй.
V	Лавтай болох	70-100	Төсөл хэрэгжих бүх шатанд эрсдэлтэй.

Химийн бодисын агуулах нь хор уршгийн үнэлгээний шалгуураар II зэрэглэлд хамаарах ба эрсдэл үүссэнээр байгаль орчин, хүн амын эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн уршиг нь дунд зэрэг байна. Харин эрсдэл үүссэн тохиолдолд агуулахын ажилчид хордох бөгөөд анхны тусламж болон эмнэлгийн тусламж шаардлагатай болно. “Пи Эс Си” ХХК нь химийн бодистой харьцах аюулгүй байдлыг бүрэн хангасан тохиолдолд энэхүү эрсдэл үүсэхгүй байх бүрэн боломжтой юм.

Мөн магадлалын үнэлгээний шалгуураар II зэрэглэлд хамаарах бөгөөд эрсдэл үүсэх магадлалтай. Энэхүү эрсдэл нь химийн бодисын тээвэрлэлт, хадгалалт, ачиж буулгах үед ажилчдын хариуцлагагүй байдал, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаагүйн улмаас үүсэх магадлалтай юм.

Хүснэгт 5. Эрсдэлийн үнэлгээний матриц

Магадлал	Үр дагавар				
	Ялимгүй	Бага	Дунд	Их	Гамшиг
Бараг болохгүй	L	L	M	M	H
Магад болохгүй	L	M	M	H	H
Болзошгүй	L	M	H	H	E
Магад болох	M	M	H	E	E
Лавтай болох	M	H	H	E	E

Хүснэгт 6. Эрсдэлийн түвшин

Эрсдэлийн түвшин	Удирдлага, зохион байгуулалт
L бага эрсдэл	Төсөл хэрэгжүүлэгчийн дотоод үйл ажиллагааны журмаар зохицуулж болох
M дунд эрсдэл	Төсөл хэрэгжүүлэгч хариуцах ба болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөтэй байх
H их эрсдэл	Төсөл хэрэгжүүлэгч болон орон нутгийн захиргаа анхааран ажиллах шаардлагатай

Е гамшгийн хэмжээнд
хүрсэн эрсдэл

Төсөл хэрэгжүүлэгч, нийслэлийн мэргэжлийн хяналтын газар, нийслэлийн онцгой байдлын газар зэрэг байгууллагууд анхааран ажиллах шаардлагатай.

“Пи Эс Си” ХХК нь химийн бодистой аюулгүй ажиллах дүрэм баримтлаагүй, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаагүй тохиолдолд төслөөс гарч болзошгүй эрсдэл дунд зэрэг (М) байна. Энэхүү үүсэж болзошгүй эрсдэлийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэхийн тулд төсөл хэрэгжүүлэгч бид өөрийн гэсэн төлөвлөгөө хөтөлбөр боловсруулан цаашид анхааран ажиллах шаардлагатай юм. Мөн эрсдэл үүссэн тохиолдолд төсөл хэрэгжүүлэгч хариуцах бөгөөд орон нутгийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагуудад яаралтай мэдэгдэн үүссэн сөрөг нөлөөллийг арилгах арга хэмжээг нэн даруй зохион байгуулах шаардлагатай.

4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилготой билээ.

“Пи Эс Си” ХХК нь байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээг иж бүрэн хамруулж, Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг жил бүрийн төсөв, төлөвлөгөөндөө тусган энэхүү төлөвлөгөөг боловсруулсан болно.

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ	БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ	ХАМРАХ ХҮРЭЭ	ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА	ТУХАЙН АЖЛЫГ ХИЙЖ ГҮЙЦЭГТЭСЭН	ХАМТРАН ХЭРЭГЖҮҮЛЭГ Ч	НИЙТ ЗАРДАЛ /төг/	БИЕЛЭЛТИЙН ШАЛГУУР	БАРИМТЛАХ ХУУЛЬ, ДҮРЭМ СТАНДАРТ
АГААР ОРЧИН								
АГУУЛАХЫН ДОТОР ОРЧНЫ АГААРЫН БОХИРДОЛТ ҮҮСЭХ	Агуулахад суурилуулсан агааржуулах төхөөрөмжийг тогтмол ажиллуулах, ажиллагааг бүрэн эсэхийг шалгах	Агуулах	2022 онд	Бүрэн хийгдсэн	Пи Эс Си ХХК	-	Агааржуулах төхөөрөмжийг тогтмол шалгаж байв.	Агаарын ба агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, MNS 0017-2-3-16:1998 (хүн ам суурьшсан хэсгүүдэд) Бензин хөдөлгүүрт MNS 5013:2003 Дизель хөдөлгүүрт MNS 5014:2003 /ЗГ-ын 2009 оны 351 дүгээр тогтоолын хавсралт –Ус ашигласаны төлбөрийн хувь хэмжээ/ / БО-ны сайдын 1995 оны 153 дугаар тушаалын хавсралт 4 –“ Зүлэг, талбайн усалгааны түр норм/
	Хадгалагдаж буй хийнүүдийн ууршилтад өөрсдийн төхөөрөмжөөр байнга хяналт тавьж байх	Агуулах	Тогтмол	Бүрэн хийгдсэн	Пи Эс Си ХХК	-	Dräger X-Am5000 өөрсдийн багажаар хяналтыг тогтмол хийсэн.	
ГАДНА ОРЧИНД	Автобусны жолоочид болон замын хөдөлгөөнд оролцож буй жолооч, явган иргэд Дунд голын эрэгт бие засч орчныг нь ихээр бохирдуулж байгааг зогсоохын тулд Дунд голын эрэг дагуу Дэлгэр хотхоны автобусны буудлын ард хаалт хашаа хийж дунд голын эргийг бохирдуулахаас хамгаалах	Компанийн орчны 50 м газарт	Жилд 1 удаа	Бүрэн хийгдсэн	Пи Эс Си ХХК	275 000	Орчны бохирдлыг багасгахын тулд автобусны буудал дээр бие засахыг хориглосон анхааруулах самбар хийсэн.	

	Тоосжилт ихтэй үед тоосжилтыг бууруулж гадна талбайг услах	Компанийн эзэмшил газар	Тухай бүр	Бүрэн хийгдсэн	Пи Эс Си ХХК	50 000	Гадна талбайн бут зүлэг услахдаа хамт орчныг чийгшүүлж усалж байв.	
ХӨРСӨН БҮРХЭВЧ								
ХЭРЭГЛЭЭНИЙ АШИГЛАСАН УСЫГ ХӨРСНИЙ БОХИРДОЛ ҮҮСЭХЭЭС СЭРГИЙЛЭХ	Хатуу хог хаягдлыг тогтмол хугацаанд зөөвөрлөж байх	Компанийн эзэмшил газар	2022 он Тогтмол	Бүрэн хийгдсэн	ХУД ТҮК		Ахуйн хогийг ХУД-ийн ТҮК ачиж зөөвөрлөдөг.	Байгаль орчныг хамгаалах тухай хууль, БОНБУ тухай хууль, Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль MNS 5850:2008 Хөрс бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ Энэ стандартаар Монгол орны нутаг дэвсгэр дээрх хөрсөнд агуулагдаж болох бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх (хүлцэх) дээд хэмжээг тогтоох бөгөөд тус стандартад заасан хэмжээнээс давсан тохиолдолд тухайн хөрсийг бохирдолд орсон гэж үзнэ. MNS 5916 : 2008 Газар шорооны ажлын үед үржил, шимт хөрс хуулалт, хадгалалт
	Ахуйн зориулалттай хэрэглэсэн усыг соруулж зөөвөрлүүлэх	Компанийн эзэмшил газар	2022 он Тогтмол	Бүрэн хийгдсэн	Рээжил ХХК	3 000 000	Бохир усыг тусгай зориулалтын машинаар зөөвөрлүүлэхээр “Рээжил” ХХК-тай хамтран ажилладаг.	
УРГАМЛАН НӨМРӨГ								
УРГАМЛАН НӨМРӨГ ДОРОЙТОХ	“Тэрбум мод тарих үндэсний хөдөлгөөн”-нд үргэлжлүүлэн оролцож хавар, намар 2 удаа мод тарих	ХУД Зэвсэгт хүчний 310-р ангийн мод үржүүлгийн төв	2022 онд 2 удаа	Бүрэн хийгдсэн	Пи Эс Си ХХК	1499000	Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд ХУД-ийн Өлзийт хорооллын урд байрлах Зэвсэгт хүчний 310-р ангийн мод үржүүлгийн төвд 5 сард болон 9 дүгээр сард мод тарьсан. (24ш бэсрэг	Байгаль орчны багц хууль, Байгалийн ургамлын тухай хууль



Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний нийт зардал 6 084 000

Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

АРГА ХЭМЖЭЭ	ҮЙЛ АЖИЛЛАГАА	ХАМРАХ ХҮРЭЭ	ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА	ТУХАЙН АЖЛЫГ ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН ЭСЭХ	ХАРИУЦАН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ	НИЙТ ЗАРДАЛ /төг/	БИЕЛЭЛТИЙН ШАЛГУУР	БАРИМТЛАХ ХУУЛЬ, ДҮРЭМ СТАНДАРТ
СУРГАЛТ, ЗААВАРЧИЛГАА	Химийн бодистой харьцах, тээвэрлэхэд зөв зохистой ажиллах сургалт, зааварчилгаа өгөх	Агуулах орчимд, хэрэглэгчид хүргэх замд	2022 онд 1 удаа	Бүрэн хийгдсэн	Пи Эс Си ХХК	-	2022 оны 9-р сарын 16-нд “ХОРТОЙ АЮУЛТАЙ ХИМИЙН БОДИСЫН УДИРДЛАГЫН СИСТЕМД ХИМИЙН ХОРТОЙ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫН УДИРДЛАГЫГ САЙЖРУУЛАХ” ААН-дэд зориулсан сургалтанд байгаль орчны асуудал хариуцсан ажилтан Б.Пүрэвжав хамрагдав. Сургалтын хөтөлбөр хавсаргав.	ХАБЭА тухай хууль
ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ХӨДӨЛГӨӨН ХЯНАХ	Химийн бодис тээвэрлэж буй тээврийн хэрэгслийн хөдөлгөөн тээвэрлэлтийг GPS – ээр хянах	Компанийн тээврийн хэрэгсэл	2022 он Тогтмол	Бүрэн хийгдсэн	Пи Эс Си ХХК	1800000	Ачаа бараа тээвэрлэх бүрт ХАБЭА-н ажилтан хяналт тавьж байсан.	

[illegible]

Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

[illegible]

БО-ны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ

АРГА ХЭМЖЭЭ	ХАМРАХ ХҮРЭЭ	ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА	ТУХАЙН АЖЛЫГ ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН ЭСЭХ	ХАРИУЦАН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ	НИЙТ ЗАРДАЛ /төг/	БИЕЛЭЛТИЙН ШАЛГУУР	БАРИМТАХ ХУУЛЬ ДҮРЭМ СТАНДАРТ
Агуулах болон ажлын байрыг гал унтраах хэрэгслийн хангамж нэмэгдүүлэх арга хэмжээг авах	Агуулах	2022 онд	Бүрэн хийгдсэн	Пи Эс Си ХХК	269 500	Гал унтраагуур, утаа мэдрэгчүүдийн ажиллагааг тогтмол шалгаж байв. Утаас мэдрэгч, шиддэг хор, аваарын гэрэл нэмж байршуулав.	БО багц хуулиуд, холбогдох дүрэм журам стандарт, Усны тухай хууль, Байгалийн нөөц ашигласан төлбөрийн тухай хууль, ЗГ-н тогтоол, усны нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг тогтоох, хөнгөлөх тухай, бусад холбогдох хууль тогтоол, журам, Гамшгаас хамгаалах тухай хууль, 2003 (сүүлийн нэмэлт өөрчлөлт 2012 оны 5 сарын 17), MNS5078-2001, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, Үйлдвэрлэлийн эрүүл ахуй” MNS ISO 13688 : 2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Ажлын тусгай хувцас-Ерөнхий шаардлага
Гал түймрийн үед хэрхэн ажиллах талаар ажиллагсдын дунд сургалт зохион байгуулах	Агуулахын ажилчдад болон шинээр орсон ажилчид	2022 онд 1 удаа	Бүрэн хийгдсэн	Пи Эс Си ХХК	-	НОБГ-ын сургалтын танхимд 4 ажилтан гамшгаас хамгаалах сургалтанд хамрагдав.	
Ажилчдын байгаль орчныг хамгаалах мэдлэг, экологийн боловсролыг дээшлүүлэх	Агуулахын ойр орчимд	2022 онд	Бүрэн хийгдсэн	Пи Эс Си ХХК	-	2 удаагийн мод тарих үед бүх ажилчид мод хэрхэн зөв суулгах заавар зөвлөмж авч биечлэн оролцов.	
Болзошгүй осол, хүний амь насанд аюул учруулж болох нөхцлүүдээс урьдчилан сэргийлэх	Агуулахын ойр орчимд	2022 онд	Бүрэн хийгдсэн	Пи Эс Си ХХК	-	ХАБАЭ ийн ажилтан ажлын байрны аюулгүй байдалд тогтмол хяналт тавьж ажиллаж байв. Мөн “Тэнгэр даатгал” ХХК-тай хамтран бүх ажилчдад эрсдлийн тухай сургалт зохион байгуулав.	
Компаний ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулж байх	Компаны бүх ажилчид	2022 онд 1 удаа	Бүрэн хийгдсэн	Пи Эс Си ХХК		Бүх ажилчид эрт илрүүлгийн үзлэг	

[illegible]

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, түүний үр дүнг тайлагнах, хэлэлцүүлэх төлөвлөгөөний биелэлт

Орчин	Байгаль орчныг хамгаалах, нөлөөллийг бууруулах	Хамрах хүрээ	Хэрэгжүүлэх хугацаа	ТУХАЙН АЖЛЫГ ХИЙЖ ГҮЙЦЭТГЭС ЭН ЭСЭХ /Хийгдсэн, хийгдээгүй гүйцэтгэлийн хувь/	ХАРИУЦАН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ	НИЙТ ЗАРДАЛ /мян.төг/	БИЕЛЭЛТИЙН ШАЛГУУР	БАРИМТАХ ХУУЛЬ ДҮРЭМ СТАНДАРТ
Хөрсөн бүрхэвч	Хөрсний химийн найрлага, элэгдэл эвдрэлийн үзүүлэлтүүд	Оффисын орчмоос	2022 он Жилд 1 удаа	Бүрэн хийгдсэн	Пи Эс Си ХХК	72000	Цаг уур, орчны шинжилгээний газар, БО хэмжил зүйн төв лаборатори	MNS 5850:2008
Орчны хяналт шинжилгээний нийт зардал 72000 төгрөг.								

“Пи Эс Си” ХХК-ний “Химийн бодис импортлох, худалдах, химийн бодисын агуулах” төслийн 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал нийт **8 832 450** төгрөг болсон.

ДҮГНЭЛТ

“Пи Эс Си” ХХК-ийн хэрэгжүүлж буй төслийн БОМТ-ий биелэлтийн тайланг хийж гүйцэтгэснээр дараах дүгнэлтэд хүрч байна. Үүнд:

2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг үндэслэн хийгдсэн ажлын талаарх хүснэгт, зурган мэдээллүүдийг холбогдох гэрээ, шаардлагатай материалуудыг тайланд тусгаж баталгаажууллаа. 2022 онд химийн хорт болон аюултай бодисыг экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, ашиглах, худалдах аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг 2022 оны 4 сарын 12нд шинэчилж авсан бөгөөд бэхэлгээний шингэн тэлэгчүүд буюу бетонд арматур төмөр анкерлагч шаваас, чигжээс, силикон, галаас тусгаарлах бүтээгдэхүүнүүд зэрэг 20 нэр төрлийн бүтээгдэхүүнүүд нь 2020 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн А/60, А/12 дугаар тушаалын 2.1.4 ба 2.1.4.2.-т заасны дагуу Барилгын материалын норматив, стандарт шаардлага хангасан гэрчилгээтэй, үйлдвэрлэгчийн савлагаатай барилгын цавуу, эмульс, чигжээс, шаваас нь тусгай зөвшөөрөл шаардахгүйгээр импортлох болсонтой холбогдуулан хасагдсан. Мөн 18 төрлийн холимог тест газнуудыг өмнөх онуудад нэг ч импортлоогүй учраас хасуулав. Ингэснээр Пи Эс Си ХХК-ний импортлох химийн бодис 66-аас 27 нэр төрөл болж буурсан. 2022 оны хугацаанд химийн бодис агуулсан бүтээгдэхүүнийн худалдан авалт бүрт хор аюулын лавлагааг тогтмол дагалдуулж өгч байв.

“Тэр бум мод” үндэсний хөтөлбөр нь уур амьсгалын өөрчлөлт, гол мөрөн булаг шанд ширгэх, байгаль орчны доройтол, цөлжилт зэрэг асуудлуудтай нэгэн зэрэг тэмцэх өндөр ач холбогдолтой учраас “Пи Эс Си” ХХК нь энэхүү хөтөлбөрийг бүрэн дэмжин 5 сард болон 10 сард 2 удаа мод тарьж оролцлоо. Цаашид дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд мод тарих ажлыг үргэлжлүүлэхээр 2023 оны төлөвлөгөөндөө тусгав.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Байгаль орчныг хамгаалах хууль, Усны тухай хууль, Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, холбогдох дүрэм журмууд болон 2017 онд хийгдсэн БОНБНҮ-ний тайлан, 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө зэргийг үндэслэн тус оны менежментийн төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлж ажилласан гэж үзэж байна.

Цаашид химийн бодис агуулсан бараа бүтээгдэхүүнүүдийг тээвэрлэх, хадгалах, худалдаалах үед хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагаанд байнга хяналт тавьж байх нь химийн бодисыг хадгалах, түгээх явцад үүсэж болзошгүй нөлөөллийг багасгах, сааруулахад чухал үүрэгтэй юм. Мөн хог хаягдлыг бууруулах арга аргачлалыг судалж, хэрэгжүүлэх нь чухал хэвээр байна.

ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫГ ЭКСПОРТЛОХ,
ИМПОРТЛОХ, ХИЛ ДАМЖУУЛАН ТЭЭВЭРЛЭХ, ҮЙЛДВЭРЛЭХ,
АШИГЛАХ, ХУДАЛДАХ АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСТАЙ

ЗӨВШӨӨРӨЛ

Огноо: 2022-04-12

Дугаар: 0002151

Улаанбаатар хот

Аж ахуйн нэгжийн нэр: Пи Эс Си ГХО ХХК

Аж ахуйн нэгжийн гэрчилгээний дугаар: 9019021042

Регистрийн дугаар: 2822733

Хаяг: Улаанбаатар, Хан-Уул, 3-р хороо, Үйлдвэрийн гудамж, 68/1

Утас: 75754584, 75754583

Дараах химийн хортой, аюултай бодис:

Импортлох, ашиглах, худалдах

аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тусгай

зөвшөөрлийг

2022.04.12-2025.12.31

хүртэл хугацаагаар олгов.

№	Бодисын нэр		Томьёо	Олон улсын бүртгэлийн дугаар /CAS/	Ангилал	Үйлдвэрлэсэн улс	Хэмжээ
	Монгол	Олон улсын					
1	Хавсралтад дурдсан 27 нэр төрлийн бодис						
2							
3							
4							
5							
6							
7							
8							

Улсын хилээр нэвтрүүлэх боомт: Замын-Үүд, Сүхбаатар, Алтанбулан, Чингис хаан

Зөвшөөрөл олгосон: Байгаль орчин, аялал жуулчлалын яам
Төрийн нарийн бичгийн дарга

Э. БАТТУЛГА /


Химийн хорт болон аюултай бодисын бодлого
зохицуулалт хариуцсан мэргэжилтэн

Ц. БАТЖАРГАЛ /

**Химийн хорт болон аюултай бодисыг
Импортлох, ашиглах, худалдах 0002151 дугаартай
тусгай зөвшөөрлийн хавсралт**

№	Монгол нэр	Олон улсын нэршил	Томъёо	CAS дугаар	Зөвшөөрсөн хэмжээ, тн
1	Устөрөгч /агаар	Hydrogen in air	H ₂ /air	1333-74-0	0.060
2	Хүхэрт устөрөгч /азот	Hydrogen Sulphide in nitrogen	H ₂ S /N ₂	7783-06-4	0.060
3	Азот	Nitrogen	N ₂	7727-37-9	0.060
4	Азотын оксид /азот	Nitrogen Monoxide in nitrogen	NO /N ₂	10102-43-9	0.060
5	Азотын 2-ч исэл /азот	Nitrogen Dioxide in nitrogen	NO ₂ /N ₂	10102-44-0	0.060
6	Азотын 2-ч исэл /агаар	Nitrogen Dioxide in air	NO ₂ /air	10102-44-0	0.060
7	Аммиак /азот	Ammonia in nitrogen	NH ₃ /N ₂	7664-41-7	0.060
8	Хүхрийн давхар исэл /азот	Sulfur Dioxide in nitrogen	SO ₂ /N ₂	7446-09-5	0.060
9	Хүхрийн давхар исэл /агаар	Sulfur Dioxide in air	SO ₂ /air	7446-09-5	0.060
10	Нүүрсхүчлийн хий /азот	Carbon Dioxide in nitrogen	CO ₂ /N ₂	124-38-9	0.060
11	Нүүрсхүчлийн хий /агаарт	Carbon Dioxide in air	CO ₂ /air	124-38-9	0.060
12	Нүүрстөрөгчийн дутуу исэл /азот	Carbon Monoxide in nitrogen	CO /N ₂	630-08-0	0.060
13	Нүүрстөрөгчийн дутуу исэл /агаар	Carbon Monoxide in air	CO /air	630-08-0	0.060
14	Хүчилтөрөгч /азот	Oxygen in nitrogen	O ₂ /N ₂	7782-44-7	0.060
15	Бутадиен /агаар	1,3-Butadiene in air	C ₄ H ₆ / air	106-99-0	0.060
16	Изобутан /агаар	Isobutylene in air	C ₄ H ₈ / air	115-11-7	0.060
17	Метан	Methane	CH ₄	74-82-8	0.060
18	Метан /азот	Methane	CH ₄ /N ₂	74-82-8	0.060
19	Метан /агаар	Methane	CH ₄ /air	74-82-8	0.060
20	Согтолтын тун илрүүлэгч багажийн үйл ажиллагаа хянагч /азот	Gas mixture in nitrogen	C ₂ H ₅ OH /N ₂	64-17-5	0.060
21	Хлор /азот	Chlorine in nitrogen	Cl ₂ /N ₂	7782-50-5	0.060
22	Цианид илрүүлэгч багажийн үйл ажиллагаа хянагч /азот	Cyanide in nitrogen	HCN /N ₂	74-90-8	0.003

23	Хлорт устөрөгч /азот	Hydrogen chloride in nitrogen	HCl /N ₂	7647-01-0	0.060
24	Фосфин /азот	Phosphine in nitrogen	PH ₃ /N ₂	7803-51-2	0.060
25	Холимог хий /азот	Gas mixture in nitrogen	CH ₄ , H ₂ S, CO, CO ₂ , O ₂ /N ₂	7783-06-4 630-08-0 124-38-9 74-82-8 7782-44-7 7727-37-9	0.060
26	Холимог хий /азот	Gas mixture in nitrogen	CO, CO ₂ , O ₂ /N ₂	630-08-0 124-38-9 7782-44-7	0.060
27	Шохойн чулуу (Нүүрсхүчлийн хий шингээгч)	Draegorsorb (CO ₂ Absorber)	Ca(OH) ₂ , NaOH, H ₂ O	1305-62-0 1310-73-2 7782-18-5	150





БАТЛАВ.
“ЦЭЦҮҮХ ТРЕЙД” ХХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Н.БИЛГҮҮН

БАТЛАВ.
“ПИ ЭС СИ” ХХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Ч.ЭРДЭНӨЦЭЦЭГ



АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ТЭЭВЭРЛЭЛТИЙН ГЭРЭЭ

2022 оны 1 сарын 21 өдөр

№Т-22/09

Улаанбаатар хот

Энэхүү гэрээ нь №Ш-22/014 тоот “Аюултай хог, хаягдал шилжүүлэх гэрээ”-ний салшгүй хэсэг байна.

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Нэг талаас “Цэцүүх трейд” ХХК /цаашид Тээвэрлэгч гэх/ төлөөлж Үйлдвэрийн дарга албан тушаалтай Б.Дарамбазар, нөгөө талаас “Пи Эс Си” ХХК-г /тээвэрлүүлэгч гэх/ төлөөлж Оффис менежер албан тушаалтай Банзрагч овогтой Пүрэвжав бид харилцан тохиролцож Монгол улсын Иргэний хууль, Хог хаягдлын тухай хууль Засгийн газрын 2018 оны 116-р тогтоолын 1,2-р хавсралт болох “Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх тайлагнах журам”, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 02-р сарын 02-ны өдрийн А/21 тоот тушаал болон Байгаль орчны аюулгүй байдалтай холбогдох хууль, журмыг үндэслэн энэхүү гэрээг байгуулав.

НЭГ. ГЭРЭЭНИЙ АГУУЛГА

- 1.1 Энэхүү Гэрээгээр Тээвэрлэгч нь Тээвэрлүүлэгчийн даалгаврын дагуу Улаанбаатар хот, Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт орших “Пи Эс Си” ХХК-с Аюултай хог, хаягдлын дагалдах бичигт заасан аюултай хог хаягдлыг Төв аймаг, Сэргэлэн сум, 1-р багийн нутаг дэвсгэрт орших “ЦЭЦҮҮХ ПЕ&ПП ДАХИН БОЛОВСРУУЛАХ ЭКО ҮЙЛДВЭР”-т тээвэрлэн хүргэх ажлыг энэ Гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэх, зохих ёсоор хүлээлгэн өгөх, Тээвэрлүүлэгч нь тээврийн хөлсийг төлөх, талууд эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагатай холбоотой харилцааг зохицуулна. Энэхүү Гэрээгээр зохицуулагдаагүй харилцааг №... тоот “Аюултай хог хаягдал шилжүүлэх” гэрээ, Монгол Улсын Иргэний хууль болон холбогдох бусад хууль, тогтоомжоор зохицуулна.
- 1.2 Тээвэрлэгч ачаа, барааг тээвэрлэхтэй холбоотой үйл ажиллагаанд Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, стандартыг баримтална.

ХОЁР. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

- 2.1 Тээвэрлэлтийн гэрээний хугацаа 2022 оны 1 сарын 21 өдрөөс 2023 оны 1 сарын 21 өдөр хүртэл жилийн хугацаатай байна.
- 2.2 Энэ гэрээ хэрэгжиж эхлэх огнооноос эхлэн, гэрээний зүйлүүдийн дагуу хугацаанаас нь өмнө цуцлагдахаас бусад тохиолдолд, дуусгавар болох огноог дуусталх хугацаанд хүчин төгөлдөр байна.
- 2.3 Гэрээний хугацааг гагцхүү талууд харилцан зөвшилцөж, бичгээр зөвшөөрсний үндсэн дээр өөрчилнө.

ГУРАВ. ТЭЭВЭРЛЭЛТИЙН ЗАХИАЛГА

- 3.1 Тээвэрлүүлэгч аюултай хог хаягдлаа тээвэрлүүлэх захиалгаа тээвэрлэгчид албан бичгээр эсвэл info@tsetsuuh.mn мэйл хаягаар өгнө. Тээвэрлүүлэгч нь Захиалга өгөх бүртээ тээвэрлүүлэх аюултай хог хаягдал болох хуванцар сав, уут шуудайны хэмжээ, ширхэг, жингийн талаарх мэдээллийг тээвэрлэгчид өгнө.

Хуудсыг баталгаажуулсан:

Хуудсыг баталгаажуулсан:

Хуудас 1/5

Хуудас 1/5


- 3.2 Тээвэрлэгч нь тээвэрлүүлэгчийн өгсөн аюултай хог хаягдлын мэдээллийг харгалзан үзэж хавсралт №1-д дурдсан тээврийн хэрэгслүүдээсээ сонгож тухайн тээвэрлэлтийн ажлыг хийж гүйцэтгэнэ.
- 3.3 Тээвэрлүүлэгч захиалгаа өгснөөр талууд тээвэрлэлтийн хуваарийг 2 хоногийн дотор харилцан тохиролцож гаргана. Талууд харилцан зөвшилцсөний үндсэн дээр тээвэрлэлтийн огноог хуанлийн 7 өдрөөр урагшлуулж, хойшлуулж болно.
- 3.4 Тээвэрлэлтийн хуваарь гарснаас хойш тээвэрлэгч нь тээвэрлүүлэгчийн “Пи Эс Си” ХХК-ээс Аюултай хог, хаягдлын дагалдах бичигт заасан аюултай хог хаягдлыг Төв аймаг, Сэргэлэн сум, 1-р багийн нутаг дэвсгэрт орших “ЦЭЦҮҮХ ПЕ&ПП ДАХИН БОЛОВСРУУЛАХ ЭКО ҮЙЛДВЭР”-т талбай дээр гэрээний 3.3-т заасны дагуу товлосон захиалга өгсөн өдөрт очсон байна.
- 3.5 Тээвэрлэгч тээвэрлүүлэгчийн талбай дээр хүрэлцэн очсоноос хойш ... цагийн дотор тээвэрлүүлэгч нь тээвэрлэгчийн тээврийн хэрэгсэлд дагалдах бичигт дурдсан аюултай хог хаягдлаа ачиж өгнө.
- 3.6 Тээвэрлэгч нь тээвэрлүүлэгчээс аюултай хог хаягдлыг хүлээн авч тээвэрлүүлэгчийн талбайгаас гарснаас хойш ... цагийн дотор хүлээн авагчийн Төв аймаг, Сэргэлэн сум, 1-р багийн нутаг дэвсгэрт орших “ЦЭЦҮҮХ ПЕ&ПП ДАХИН БОЛОВСРУУЛАХ ЭКО ҮЙЛДВЭР”-т хүргэж өгнө.

ДӨРӨВ. ТЭЭВЭРЛЭЛТИЙН ТӨЛБӨР ТООЦОО

- 4.1 Гэрээний талууд бичгээр өөрөөр харилцан тохиролцоогүй бол тээвэрлүүлэгч талаас тээвэрлэгчээр ачаа тээвэрлүүлсэн төлбөрөө цаг тухайд нь гэрээний хавсралт №1-д тусгасан тарифаар тооцож төлнө.
- 4.2 Тээвэрлэлтийн хөлсийг дараах нөхцөлөөр зохицуулна.
- 4.2.1 Тээвэрлүүлэгч нь аюултай хог хаягдлаа тээвэрлүүлж хүлээлгэн өгснөөс хойш ажлын 3 хоногийн дотор тээвэрлэгчийн нэхэмжлэхийн дагуу 100% төлбөрийг төлнө.
- 4.2.2 Төлбөр тооцоог тээвэрлэгчийн Голомт банк, “Цэцүүх трейд” ХХК, 1715132986 тоот дансаар шилжүүлнэ.

ТАВ. ТЭЭВЭРЛҮҮЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 5.1 Тээвэрлэгчээр аюултай хог, хаягдлыг Төв аймаг, Сэргэлэн сум, 1-р багийн нутаг дэвсгэрт орших “ЦЭЦҮҮХ ПЕ&ПП ДАХИН БОЛОВСРУУЛАХ ЭКО ҮЙЛДВЭР”-т хүргүүлэх, тээвэрлүүлэгч нь хэлэлцэн тохирсон хөлс төлөх үүрэгтэй.
- 5.2 Аюултай хог, хаягдлыг тусгай зориулалт бүхий “Аюултай хог хаягдал” гэсэн тэмдэглэгээ бүхий тээврийн хэрэгслээр тээвэрлэхийг тээвэрлэгчээс шаардах эрхтэй.
- 5.3 Тээвэрлүүлэгч аюултай хог, хаягдлыг тээвэрлэгчид хүлээлгэн өгөхдөө Тэмдэг, тэмдэглэгээтэй зориулалтын саванд савласан, хог хаягдлын дагалдах бичгийн хамт ачиж өгнө.
- 5.4 Хог хаягдлын дагалдах бичгийг үнэн зөв бөглөсөн байх, хэрэв худал зөрүүтэй мэдээлснээс аюул, осол гарах, хүлээн авагч хог хаягдлыг хүлээн авахгүй байх нөхцөл байдал үүсвэл хариуцлагыг тээвэрлүүлэгч хүлээнэ.
- 5.5 Тээвэрлүүлэгч буюу Үүсгэгч нь Аюултай хог хаягдлын дагалдах бичгийг 4 хувь үйлдэж, гарын үсэг тамга тэмдэг дарж өөртөө 1 хувь, тээвэрлэгчид 1 хувь, хүлээн авагчид 2 хувийг илгээж, хүлээн авагчаас хүлээн авсан гарын үсэг, тамга тэмдэг дарагдсан 1 хувь дагалдах бичгийг буцаан авна.
- 5.6 Аюултай хог хаягдлыг гэрээнд заасан газарт хүргэж, хүлээлгэн өгөх үед хүлээн авагч нь хог, хаягдлыг хүлээн авсан тухай гарын үсэг, тамга тэмдэг дарагдсан дагалдах бичгийн 2 дах хувийг тээвэрлэгчээс шаардан авах эрхтэй.
- 5.7 Тээвэрлүүлэгч нь тээвэрлэгчид аюултай хог, хаягдлын талаарх зохих мэдээлэл, зааварчилгаагаар бүрэн хангах үүрэгтэй.
- 5.8 Талууд аюултай хог хаягдлыг хүлээлцэх үед хог хаягдал нь дагалдах бичиг, төрөл, тоо хэмжээтэйгээ таарч байгаа эсэхийг хамтран шалгах үүрэгтэй. Хэрэв таарахгүй байвал ачих аюултай хог хаягдлын мэдээллийг үнэн зөв агуулсан дагалдах бичгийг дахин үйлдэж тээвэрлэгчид өгнө.
- 5.9 Аюултай хог, хаягдлыг хамтран шалгасан боловч тухайн үед нуугдмал байдалд байсан химийн бодисын үл зохицол, савны ёроолыг зохих журмын дагуу шавхаагүй байдлыг илрүүлэх боломжгүй нөхцөл байдлаас үүдэж байгаль орчин, хүн, амьтан, тээврийн хэрэгсэл зэрэгт хохирол учирвал тээвэрлүүлэгч хариуцлага хүлээнэ.
- 5.10 Аюултай хог, хаягдлыг тээвэрлэгчид зохих журмын хүлээлгэн өгч ачуулснаар эрсдэл тээвэрлэгчид шилжинэ. Гагцхүү дагалдах бичгийг худал, зөрүүтэй бөглөсөн болон гэрээний 5.9-д



Хуудсыг баталгаажуулсан:

заасан нөхцөл байдал үүссэнээс байгаль орчин, хүн, амьтан, эд хөрөнгөд хохирол учирвал тээвэрлүүлэгч хариуцлага хүлээнэ.

ЗУРГАА. ТЭЭВЭРЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 6.1 Тээвэрлэгч нь тээвэрлүүлэгчийн аюултай хог хаягдлыг Төв аймаг, Сэргэлэн сум, 1-р багийн дэвсгэрт орших "ЦЭЦҮҮХ ПЕ&ПТ ДАХИН БОЛОВСРУУЛАХ ЭКО ҮЙЛДВЭР"-т хүргэх үүрэгтэй.
